

АГУУЛГА

Оршил	4
Нэг. Судалгааны түүвэрлэл	6
Хоёр. Монгол улсын эдийн засгийн өөрчлөлтийн талаар	8
Гурав. Эдийн засаг ирэх жилд /хүлээлт/	10
Дөрөв. Хүн амын сарын орлогын өөрчлөлтийн талаар	11
Тав. Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт	14
Зургаа. Ажил эрхлэлтийн талаар	17
Долоо. Бизнесийн орчны талаар	20
Найм. Ядуурал, түүний төлөв байдлын талаар	22
Ес. Ханшны өөрчлөлтийн талаар	25
Арав. Хүн амын цалин хөлсний өөрчлөлтийн талаар	26
Арван нэг. Хөрөнгө оруулалтын орчны талаар	29
Арван хоёр. Эдийн засгийн хоцрогдлыг даван туулах талаар	31
Арван гурав. Амьдрах боломжийн талаар	32
Санал дүгнэлт	34

Оршил

„Хэрэглэгчдийн итгэлийн индекс,, судалгааг явуулж эхэлснээс хойш 5 жил өнгөрч байна. Энэ хугацаанд дэлхий дахинд болоод Монгол улсад их зүйл өөрчлөгдлөө. Ялангуяа эдийн засгийн өсөлт, бизнесийн орчин, хөдөлмөр эрхлэлт, ядуурал, ажилгүйдэл, хүн амын орлого зарлагын хувьд эерэг болоод сөрөг өөрчлөлтүүд ихээр гарсан нь тодорхой. Даяаршлал хурдацтай өрнөн дэлгэрэж байгаа өнөө үед Монгол мэтийн жижиг, нэн ядуу буурай орнуудын хувьд олон улсын байгууллагууд, хандивлагчдын туслалцаа дэмжлэгийг үр бүтээлтэй ашиглан эдийн засгаа хөгжүүлэх, ард түмнийхээ аж амьдралыг сайжруулах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Өнгөрсөн жилийн хугацаанд Монгол орны хувьд эдийн засаг, бизнесийн орчинд ихээхэн өөрчлөлт, шинэчлэл гарсан билээ. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын дээд хэмжээ 40 хувь байсныг 30 болгон буурууллаа. Түүнчлэн төр захиргааны зүгээс бизнес эрхлэгчдэд учруулдаг элдэв дарамт шахалтыг арилгах тал дээр ч нилээд ахиц дэвшил гарсан. 2004 оны 4 сард Монголын бизнес эрхлэгчдийн анхдугаар Их чуулганыг МҮХАҮТ Засгийн газартай хамтран амжилттай зохион байгуулсан ба бизнес эрхлэгчдийн тус чуулганд гарсан санал шүүмжлэл, бизнес эрхлэгчдийн дунд явуулсан судалгааны үр дүн зэрэгт үндэслэн Засгийн газраас бизнесийн орчныг сайжруулах тухай тусгай тогтоол гаргаж авч хэрэгжүүлэх үйл ажиллаганы төлөвлөгөөг баталсан нь манай орны хувьд томоохон чухал үйл явдал боллоо гэж үзэж болно.

Өнгөрсөн жилд эдийн засагт гарсан бас нэг чухал ач холбогдол бүхий үйл явдал бол ОХУ-д төлөх ёстой байсан их өрийг төлж барагдуулсан явдал юм. Ингэснээр эдийн засаг дахь дарамт буурч эдийн засгийн өсөлт нэмэгдэх боломж нээгдэж байна. Энэ мэтчилэн сайн сайхан зүйл их байгаа ч гэсэн бас анхаарах асуудлууд ч цөөнгүй байна. Тухайлбал бизнес дэх төрийн оролцоо багасахгүй байна. Олон зөвшөөрөл лиценц авдаг, хүнд суртал гаргадаг, чирэгдүүлдэг, бизнесийнхнээс элдэв хандив тусламж нэхэж дарамталах, далд эдийн засаг өсөн нэмэгдэж байгаа, газрын наймаа, авилгал өссөөр байгаа зэрэг бизнес эрхлэхэд учирч буй сөрөг саад бэрхшээлүүд ч их байна.

Тус судалгаа нь олон нийтийн дунд явуулсан анкетын санал асуулгын дүнд үндэслэн улс орны эдийн засгийн өнөөгийн болон хэтийн төлөв байдал, ажил эрхлэлт, хүн амын орлого, өргөн хэрэглээний барааны үнэ ханш, ядуурал, бизнесийн орчин зэрэгт өнгөрсөн нэг жилийн хугацаанд ямар ахиц дэвшил, өөрчлөл, бууралт гарсан хэмээн хэрэглэгчид үзэж буйг гаргахад чиглэгдсэн болно. Энэхүү судалгааны үр дүн нь өнөөгийн авч явуулж буй эдийн засаг, бизнесийн чиглэлтэй бодлого, шийдвэр, арга хэмжээнүүд нь зорилгоо биелүүлж чадаж буй эсэхийг харуулах, олон түмний зүгээс эдгээр бодлого шийдвэрт өгч буй үнэлэт дүгнэлтийг илэрхийлж байгаа тул Засгийн газар, бодлого боловсруулагч, түүнийг хэрэгжүүлэгчдэд цаашдын ажил хэрэгтээ юунд анхаарах, ямар арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохистой талаар санаа оноо өгөх чухал ач холбогдолтой хэмээн бид үзэж байна.

Нэг. Судалгааны түүвэр

Энэхүү судалгаанд нийт 628 хүн хамрагдсан ба судалгааг Улаанбаатар хотын хэмжээнд 2004 оны 5 сард хийсэн. Улаанбаатар хот нь манай орны хувьд эдийн засаг, бизнесийн гол төв болох учраас нийт улс орны эдийн засаг, бизнесийн төлөв байдлыг бүрэн тодорхойлох, төлөөлөх боломжтой гэж үзсэн болно. Түүнчлэн нийт хүн амын бараг гуравны нэг нь төвлөрөн суурьшсан учир хүн амын төлөөллийг ч хангах бололцоотой гэж үзсэн. Судалгаанд оролцогчдыг сонгохдоо өмнөх жилийн

судалгаанд хамрагдагсадыг түлхүү оруулах бодлого баримталсан бөгөөд ингэснээр жилийн хугацаанд тэдний ажил хөдөлмөр, ахуй амьдралд төр засгийн бодлого шийдвэр ямар нөлөө үзүүлсэн болон орлого зарлагад гарсан өөрчлөлтийг бодитойгоор гаргаж ирэх боломж олдсон ба ингэснээр судалгааны үр дүн ч үнэн зөв гарах юм.

Өнөөдөр манай улсын хувьд анхаарал татаж буй нэг чухал асуудал бол эдийн засаг, бизнес, нийгмийн амьдрал дахь эмэгтэйчүүдийн оролцоо, тэдний өсөн нэмэгдэж буй хувь хэмжээ юм. Үүнийг тус судалгаанд хамрагдагсадын хүйсийн харьцаа бүр ч тод томруунаар илэрхийлж байгааг өмнөх судалгаануудаас ч харж болно. Анхны буюу 2000 оны судалгаанд оролцогчдын 52.4 хувь нь эрэгтэйчүүд байсан бол үүнээс хойш эмэгтэйчүүд дийлэнхи хувийг эзлэх боллоо. Өөрөөр хэлбэл 2000 оноос хойш эмэгтэйчүүд бизнес, нийгэмд хүчтэй түрэн орж ирж байна гэсэн үг юм. Эндээс хийх гол дүгнэлт бол төр засаг, бизнесийн хүрээнийхний зүгээс нийгэм, эдийн засгийн шинжтэй аливаа бодлого шийдвэр гаргахдаа жендерын асуудлыг анхаарах, түүнтэй уялдуулан зохицуулах нийгмийн шаардлага гарч иржээ гэдгийг зөвөөр ухамсарлан ойлгох, хэрэгжүүлэх явдал юм.

Судалгаанд хамрагдагсадын хүйсийн харьцаа

	2003		2004		Өөрчлөлт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Хувь	2004/2003
Эрэгтэй	372	48.9	277	44.2	- 4.7	- 9.6
Эмэгтэй	388	51.1	351	55.8	+ 4.7	+ 9.2
Дүн	760	100.0	628	100.0		


Боловсролын хувьд судалгаанд оролцогчдын дийлэнхи буюу 80.1 хувь нь дээд, 6.1 хувь нь бүрэн дунд, 7.7 хувь нь тусгай дунд, 6.1 хувь нь бүрэн бус дунд боловсролтой хүмүүс байна. Өмнөх жилүүдийн судалгаанд оролцогчдын боловсролын төвшинтэй харьцуулахад дээд боловсролтой хүмүүсийн тоо хэмжээ жил ирэх тутам өсөн нэмэгдэж байгаа нь хувийн болоод улсын олон зуун их дээд сургуулиудыг төгсөгчдийн тоо жилээс жилд өсөн нэмэгдсээр байгаатай холбоотой нь тодорхой. Судалгаанд оролцогчдыг эрхэлж буй ажил төрлөөр ангилан авч үзвэл бизнесийн салбарт буюу хувийн хэвшилд ажиллагсад 51.5 хувь, төр захиргааны байгууллагуудад ажиллагсад 16.4 хувь, ажилгүй хүмүүс 10.7 хувь, оюутан суралцагсад 12.9 хувийг эзэлж байгаа ба үлдсэн 8.5 хувь нь янз бүрийн чиглэлийнхэн / тэтгэвэрийнхэн, олон нийтийн, гадаадын болоод ТББ-д ажилласад гэх мэт/ байна.

Боловсролын байдал

	2003 оны 5 сар		2004 оны 5 сар	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Дээд	525	69.1	503	80.1
Тусгай дунд	36	4.7	49	7.7
Бүрэн дунд	195	25.7	38	6.1
Бүрэн бус дунд	5	0.7	38	6.1
Дүн	760	100.0	628	100.0

Өнөөдөр хувийн хэвшлийнхэн манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 80 орчим хувийг үйлдвэрлэж байгаа, монголын нийт ажиллагсадын ихэнх нь тус салбарт ажиллаж байгаа, хувийн хэвшил эдийн засаг, бизнесийн өсөлтийг тодорхойлж байгаа утгаар нь тус салбараас түлхүү хамруулсан болно. Мөн төр, захиргааны буюу төрийн байгууллагад ажиллагсадын санал бодол ч тус судалгаанд нилээд хувийг эзэлж байгааг хэлэх нь зүйтэй болов уу.

Судалгаанд хамрагдагсадын ажил эрхлэлтийн байдал



Ард түмний ахуй амьдралын төвшинг тодорхойлдог үндсэн хүчин зүйлс нь орлогын байдал билээ. Дэлхий нийтийн жишгээр өдөрт нэг америк доллараас бага орлоготой бол тухайн хүнийг нэн ядуу гэж тодорхойлдог. Мянганы хөгжлийн зорилтын хүрээнд иймэрхүү нэн ядуу амьдралтай хүмүүсийн эзлэх хувь хэмжээг бууруулах асуудлыг нэн тэргүүний зорилт болгон тавьсан бөгөөд манай улсын хувьд ядуу болон нэн ядуу амьдралтай хүмүүсийн нийт хүн амд эзлэх хувь хэмжээ өндөр /60 гаруй хувь/ байгаа юм.

Тус судалгааны хувьд ихэнх нь ямар нэг тодорхой ажил, хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс хамрагдсан бөгөөд энэ ч үүднээс тэдний орлогын байдал харьцангуй өндөр гарч байна. Засгийн газраас төрийн албан хаагчдын цалин хөлсийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлсэн нь ч үүнд нөлөөлсөн байж болох үндэстэй. Хамгийн гол нь судалгаанд оролцогчдын ихэнх нь хувийн хэвшилд ажилладаг нь тэдний цалин хөлсний хэмжээ ийнхүү өндөр гарахад хүргэсэн гол хүчин зүйл юм.

Сарын 30.0 мянга хүртэл төгрөгийн орлоготой хүмүүс судалгаанд оролцогчдын 10.7 хувь, 30.0-50.0 мянган төгрөгийн орлоготой хүмүүс 5.8 хувь, 50.0-70.0 мянган төгрөгийн орлоготой нь 9.8 хувь, 70.0-90.0 мянган төгрөгийн орлоготой нь 7.2 хувь, 90.0-110.0 мянган төгрөгийн орлоготой нь 11.9 хувь, 110.0-130.0 мянган төгрөгийн орлоготой хүмүүс 12.3 хувь, 130.0-150.0 мянган төгрөгийн орлоготой нь 19.6 хувь, 150.0 мянгаас дээш төгрөгийн орлоготой хүмүүс 22.4 хувийг тус тус эзэлж байна.

Судалгаанд оролцогчдын орлогын байдал, 2004

	2004	
	Тоо	Хувь
30000 хүртэл	67	10.7
30001-50000	36	5.8
50001-70000	62	9.8
70001-90000	45	7.2
90001-110000	75	11.9
110001-130000	77	12.3
130001-150000	123	19.6
150000-аас дээш	143	22.4
Дүн	628	100.0

Хоёр. Монгол улсын эдийн засаг өнгөрсөн нэг жилд

Бид судалгаагаа явуулахдаа тодорхой давтамжтай буюу тодорхой хугацааны хүрээнд явуулахыг хичээж буй бөгөөд 2003 оноос хойш тогтмол 5 сард явуулж байгаа болно. Учир нь өнгөрсөн жилийн эдийн засаг, нийгмийн албан ёсны үзүүлэлтүүд энэ хугацаанд бүрэн гарч дуусдаг ба олон түмэн ч албан болоод албан бус үзүүлэлтүүд, тоо баримтуудтай танилцаж амждагаас гадна өнгөрсөн жилийн хугацаанд өөрийн амьдрал ахуйд гарсан өөрчлөлтүүдийн талаар тодорхой анализ шинжилгээ хийж өөрийн гэсэн байр суурь, үзэл бодолтой болж амждагийг харгалзан үзсэн юм. Түүнээс гадна улс орны эдийн засгийн өнөөгийн байдлын талаарх олон түмний санаа бодол ямар байгаа болон цаашдын төлөв байдлын талаар ямаршуу хүлээлттэй байгааг гаргадгаараа тус судалгаа онцлогтой билээ.


Хэрэв та бүхэн статистикийн тоо баримтаас харвал Монгол улсын эдийн засаг 2003 онд ихээхэн өссөн үзүүлэлтүүдийг үзэх болно. Өөрөөр хэлбэл төрийн байгууллагын гаргасан албан ёсны тоо баримтууд нь өнгөрсөн жилийн хугацаанд ДНБ-ний өсөлт нэмэгдэж 5.6 хувь болсон, эдийн засаг өсөлтийн замдаа орлоо гэх мэт эерэг нааштай үзүүлэлтүүдийг харуулж байна. Тэгвэл олон нийт, ард түмэн, хэрэглэгч олон энэ талаар ямар санал бодолтой явдгийг үзье. Төр засгаас авч хэрэгжүүлж буй макро эдийн засгийн бодлого шийдвэр, арга хэмжээнүүд нь эцсийн эцэст хэрэглэгч олонд яаж тусч, нөлөөлж байгаагаар л тодорхойлогддог нь тодорхой. Энэ үүднээс зах зээл өндөр хөгжсөн, эдийн засгийн оновчтой бодлого хэрэгжүүлж буй улс орнууд хэрэглэгчдийн санал бодолд ихээхэн анхааралтай хандаж бодлого, шийдвэр гаргахдаа тусган оруулж байдаг нь амжилт олохын нэг гол үндэс нь болдог байна.

Судалгаанд оролцогчдоос өнгөрсөн нэг жилийн хугацаанд улс орны эдийн засаг илт сайжирсан гэж үзэх үзэлтэй хүмүүс гарсангүй. Харин бага зэрэг сайжирч өссөн гэсэн бодолтой хүмүүс судалгаанд хамрагдагсадын дотор нилээд өндөр хувь буюу 56 хувийг эзэлж байгаа нь төр засгийн эдийн засгийн бодлого шийдвэр, үйл ажиллагаанууд нь хэрэглэгч олон түмэнд бага зэрэг мэдрэгдэж эхэлж байгааг харуулж байна. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд улс орны эдийн засагт ямарч өөрчлөлт / ахиц дэвшил / гараагүй гэсэн хүмүүс судалгаанд оролцогчдын дотор нилээд хувь буюу 32.7 хувийг эзэлж байгаа нь тэдний ажил амьдралд засгийн газраас явуулж буй эдийн засаг, нийгмийн бодлого, арга хэмжээнүүд тодорхой нөлөө үзүүлж чадахгүй байгааг илтгэж байна.

Бидний анхаарал татаж буй нэг асуудал бол өнгөрсөн жилийн хугацаанд манай орны эдийн засгийн байдал, /өсөлт / орчин бага зэрэг буурсан гэсэн үзэл бодолтой хүмүүс судалгаанд оролцогчдын дотроос гараагүй явдал юм. Харин эдийн засаг маш ихээр унасан гэсэн бодолтой хүмүүсийн эзлэх хувь хэмжээ 11.3 хувь байна. Эндээс хийх нэг чухал дүгнэлт бол олон нийтийн үзэл бодол ихээхэн савлалттай буюу туйлшрах хандлагатай байгаа явдал юм. Өөрөөр хэлбэл Засгийн газрын авч хэрэгжүүлж буй эдийн засаг, бизнесийн чиглэлийн бодлого шийдвэр, үйл ажиллагаанууд нь нийгмийн нэг хэсэгт ихээхэн нааштайгаар, нөгөөд сөрөг байдалтайгаар тусч байна гэсэн үг юм. Хэрэв энэ чигээр цааш үргэжлэх юм бол нийгэмд элдэв сөрөг, гаж үзэгдэл гарч болохыг үгүйсгэхгүй.

Улс орны эдийн засгийн өнгөрсөн нэг жилийн байдалд өгсөн үнэлгээ

	2000		2003		2004	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Илт сайжирсан	2	0.29	66	8.68		0.0
Бага зэрэг сайжирсан	60	8.84			352	56.0
Огт өөрчлөгдөөгүй	335	49.34	466	61.32	205	32.7
Бага зэрэг буурсан	216	31.81				0.0
Маш ихээр унасан	66	9.72	228	30.0	71	11.3
Дүн	679	100.0	760	100.0	628	100.0



Гурав. Эдийн засаг ирэх жилд /хэрэглэгчдийн хүлээлт/

Жилийн дараа гэхэд улс орны эдийн засгийн байдал хэрхэн өөрчлөгдөнө гэж олон түмэн үзэж буй нь бодлого боловсруулагчид болоод түүнийг гардан хэрэгжүүлэгчид, түүнчлэн судалгаа шинжилгээний байгууллагуудын хувьд ихээхэн ач холбогдолтой байдаг. Энэхүү хүлээлтэд үндэслэн ямар асуудалд анхаарах, юуг онож, юунд алдаж буйгаа тодорхойлох, бодлого шийдвэрээ ямар арга механизмаар яаж хэрэгжүүлбэл зохих гээд олон асуудлыг шийдвэрлэж болдог. Одоо манай судалгаанд оролцогчид энэ талаар ямар санал бодолтой байдгийг авч үзье.


Жилийн дараа гэхэд улс орны эдийн засаг огцом өсч ард түмний ахуй амьдрал ихээхэн сайжирна гэсэн үзэлтэй хүмүүс судалгаанд оролцогчдоос огт гарсангүй. Энэ нь ч бодит байдалтай уялдаж байгаа бөгөөд манай орны өнөөгийн эдийн засгийн байдал, орчин нь иймэрхүү огцом өсөлт гаргах бололцоо чадавхи байхгүй гэдгийг харуулж байгаа юм. Харин эдийн засаг бага зэрэг өсч сайжирна гэсэн үзэлтэй хүмүүс нилээд буюу судалгаанд хамрагдагсадын 51.4 хувийг эзэлж байна. Ер нь энэ жилийн судалгаанаас ажиглагдаж байгаа нэг гол зүйл бол эдийн засаг, бизнесийн өсөлт хөгжлийн талаарх олон түмний хүлээлт үзэл бодол ихээхэн нааштай болсон явдал юм.

Ирэх жилийн эдийн засгийн байдлын талаарх олон түмний хүлээлт /хүснэгтээр/

	2003		2004		Өөрчлөлт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Хувь	2004/2003
Маш ихээр өснө			-	0.0		
Бага зэрэг өснө	162	21.3	322	51.4	+30.1	+ 2.4 дахин
Өөрчлөлт гарахгүй	508	66.8	205	32.7	-34.1	- 51.1 %
Бага зэрэг буурна	90	11.9	101	15.9	+ 4.0	- 33.6 %
Маш ихээр буурна						
Дүн	760	100.0	628	100.0		

Өнгөрсөн жилтэй харьцуулахад ирэх жилд эдийн засгийн байдалд нэг их өөрчлөлт орохгүй нэг төвшинд байна гэсэн үзэлтэй хүмүүс судалгаанд оролцогчдын 32.7 хувийг эзэлж байна. Харин судалгаанд хамрагдсан хүмүүсийн 15.9 хувь нь ирэх жилд эдийн засгийн байдал энэ жилийнхээсээ муудна гэсэн үзэлтэй байгаа юм. Эдгээрийн 6.7 хувь нь ирэх жилд эдийн засаг бага зэрэг муудна гэсэн бол 9.2 хувь нь маш ихээр муудна гэжээ. Энэ жилийн судалгааны үзүүлэлтүүдийг өнгөрсөн жил буюу 2003 оныхтой харьцуулж үзвэл ерөнхийдөө нааштай буюу эерэг дүр зураг гарч байгаа бөгөөд тухайлбал эдийн засаг дараа жилд өсч дээшилнэ гэсэн үзэлтэй хүмүүсийн харьцааг хувьчилж үзүүлбэл энэ жилд өнгөрсөн оныхоос 2.4 дахин өссөн байна. Харин эдийн засгийн байдалд нэг их өөрчлөлт гарахгүй хэвэндээ байна гэсэн хүмүүсийн хувь хэмжээ 51.1 хувиар буурсан. Гэвч энд анхаарах нэг зүйл бол эдийн засгийн байдал дараа жилд энэ жилийнхээс муудна гэсэн үзэл бодолтой хүмүүсийн хувь хэмжээ буураагүйгээр барахгүй өссөн дүн гарч байгаа юм. Өөрөөр хэлбэл 2003 онтой харьцуулахад энэ жилийн судалгаанд оролцогчдын дунд эдийн засгийн байдал цаашдаа муудах болов уу гэсэн таамаглалтай хүмүүсийн хувь хэмжээ харьцангуй их буюу 33.6 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь засгийн газраас авч хэрэгжүүлж буй одоогийн эдийн засгийн чиглэлийн бодлого шийдвэр амжилттай хэрэгжихэд эргэлзэж байна гэсэн үг бөгөөд иймээс төр засаг үүнд анхааралтай хандаж имй хариулт өгөх болсон уг шалтгааныг олж тогтоох шаардлагатай байна.

Ирэх жилийн эдийн засгийн байдлын талаарх олон түмний хүлээлт /графикаар/



Дөрөв. Орлогын өөрчлөлтийн талаар

Хүн амын амьжиргааны гол эх үүсвэр болсон орлогын асуудал аль ч засгийн газар, улс төрийн хүчнүүдийн хамгийн их анхаарал татсан, хөндүүр сэдэв байдаг. Бид орлого гэдэгт тухайн хүний тодорхой байгууллага, аж ахуйн нэгжид ажиллаад авч буй цалин хөлсийг оруулж тооцсон ба харин нэмэгдэл бусад орлогуудыг оруулаагүй. Дэлхийн нийтийн жишгээр хүн амын амьжиргааны төвшинг хэмждэг гол хэмжигдхүүн нь орлого байдаг. Өмнө нь ч бид энэ талаар цухас дурдсан билээ. Өнөөдөр манай улсад амьжиргааны баталгаажих доод төвшний хэмжээ 30 орчим мянган төгрөг байгаа нь дэлхийн бусад улс орнуудтай харьцуулахад маш бага байгаа юм. Өнгөрсөн жилийн

хугацаанд Засгийн газраас төрийн албан хаагчдын болон тэтгэвэрийн хүмүүсийн цалин, тэтгэмжийг зохих хувиар нэмсэн хэдий ч манай хүн амын орлого хамаагүй бага байгаа юм.

Өнгөрсөн жилийн хугацаанд сарын орлого нь их хэмжээгээр өссөн хүн судалгаанд оролцогчдын дунд байсангүй. Харин сарын орлого нь бага зэрэг нэмэгдсэн гэсэн хүмүүс судалгаанд оролцогчдын 39.1 хувийг эзэлсэн бол 36.9 хувийн хувьд ямар нэг өөрчлөлт /өсөлт/ гараагүй байна. Нийт судалгаанд оролцогчдын 25 хувийнхний хувьд өнгөрсөн жилийн хугацаанд сарын орлого нь багассан буюу буурсан гэсэн үзүүлэлт гарсан ба үүний дотор сарын орлого нь бага зэрэг буурсан гэсэн хүмүүс 9.1 хувь, маш ихээр буурсан гэж үзсэн хүмүүс 14.9 хувь тус тус болж байна. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцсон дөрвөн хүн тутмын нэгний хувьд өнгөрсөн жилд орлого нь ямар нэг шалтгаанаар буурсан гэсэн үг юм. Орлого нь буурах болсон шалтгаан нөхцөл нь тодорхойгүй боловч гол пакт нь орлого буурсан гэсэн үзүүлэлт бөгөөд энэ нь эдгээр хүмүүсийн хувьд төр засгийн бодлого шийдвэр, авч явуулсан арга хэмжээ нөлөөлсөн нь тодорхой.


Орлогын өөрчлөлтийн харьцуулалт, 2003-2004

	2003		2004		Өөрчлөлт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Хувь	2004/2003
Маш ихээр өссөн		0.0		0.0		
Бага зэрэг нэмэгдсэн	266	35.0	245	39.1	+4.1	+ 11.7 %
өөрчлөгдөөгүй	278	36.6	231	36.9	+0.3	+ 0.8 %
Бага зэрэг буурсан			57	9.1		
Маш ихээр буурсан	216	28.4	95	14.9	-13.5	- 52.5 %
Дүн	760	100.0	628	100.0		

Энэ судалгаагаар бид зөвхөн жилийн хугацаанд орлогод өөрчлөлт гарсан эсэхийг санал асуулгад оролцогчдоос асууж гаргасан болно. Өнөөдөр монголд орлогын ядуурал улам бүр өсөн нэмэгдсээр байгааг бодит байдал /амьдрал/ харуулж байна. Нэн ялангуяа боловсролгүй хүмүүс болон хот хөдөөгийн хооронд орлогын ялгаа зөрөө маш өндөр байгаа нь ядууралд хүргэх нэг нөхцөл болж байгаа билээ.

1998 онд Үндэсний Статистикын Газраас хийсэн амьжиргааны төвшний судалгаагаар хүн амыг нэн ядуу, ядуу, ядуу бус доод, ядуу бус дунд, ядуу бус дээд гэсэн 5 ангилалд хуваан үзэж судлахад нэн ядуу болон ядуу өрхийн тэргүүнүүдийн боловсролын түвшин нөгөө гурван ангиллынхаасаа хамаагүй доогуур хэмжээнд байгаа нь харагдсан байна.

Орлогын өөрчлөлт, 2000-2004 он



Түүнчлэн энэ судалгаагаар нийт хүн амын 35.6 хувь нь ядуурлын шугамаас доогуур буюу орлогын хувьд маш доогуур төвшинд амьдарч байгаа үзүүлэлт гарсан ба хэдийгээр энэ хооронд 6 жил өнгөрсөн хэдий ч энэ хэмжээ өнөөдөр буураагүйгээр барахгүй харин өссөн ч байж магадгүй юм.

Дундаас дээш боловсролтой өрхийн тэргүүний хувийн жин, орлогын түвшнөөр, 1998

Байршил	Нэн ядуу	Ядуу	Ядуу бус /доод/	Ядуу бус /дунд/	Ядуу бус /дээд/
Хот	31.0	47.3	57.1	66.3	73.1
Хөдөө	21.0	18.8	19.8	28.1	31.5

Эх сурвалж: Амьжиргааны түвшний судалгаа, 1998, УСГ

Одоо судалгаанд оролцогчид ирэх жилд сарын орлого нь хэрхэн өөрчлөгдөнө гэж хүлээж /таамаглаж/ байгааг авч үзье. Судалгааны дүнгээс үзэхэд нийт хамрагдсан хүмүүсийн 60 орчим хувь нь буюу ихэнх нь ирэх жил сарын орлого маань өсөх болов уу гэсэн найдлагатай байгаа нь харагдаж байна. Тухайлбал 5.1 хувь нь маш ихээр өснө гэсэн өөдрөг үзэлтэй байхад 54.6 хувь нь бага зэрэг өсч магадгүй гэсэн хүлээлттэй байна. Харин 32.9 хувь нь орлогод нэг их өөрчлөлт гарахгүй гэж үзсэн байхад 4.6 хувь нь орлого бага зэрэг буурч мэднэ гэсэн бол 2.8 хувь нь маш ихээр буурна гэсэн гутранги хүлээлттэй байна. Сарын орлого маань ирэх жилд буурна гэсэн үзэлтэй хүмүүсийн эзлэх хувийн жин 7.4 хувь байгаа нь харьцангуй бага үзүүлэлт бөгөөд хүмүүсийн энэхүү итгэл найдвар хүлээлтийг алдахгүйгээр ажиллах нь төр засгийн үйл ажиллагааны гол чиг хандлага байх ёстой нь тодорхой. Дараах хүснэгтэд 2000-2004 оны хооронд хийсэн 5 удаагийн судалгаануудын орлогын өөрчлөлтийн талаарх хүлээлтэд өгсөн саналуудыг нэгтгэн харууллаа.


	2000/01		2001/01		2002/03		2003/05		2004/05	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Маш их өснө	12	1.77	27	3.93	66	4.40			32	5.1
Бага зэрэг өснө	217	31.96	186	27.07	852	56.80	359	47.24	342	54.6
Огт өөрчлөгдөхгүй	362	53.31	321	46.72	446	29.73	321	42.24	206	32.9
Бага зэрэг буурна	75	11.05	89	12.95	96	6.40	80	10.53	28	4.6
Маш их буурна	13	1.91	64	9.32	40	2.67			20	2.8
Нийт	679	100.00	687	100.00	1500	100.00	760	100.00	628	100

Хүснэгтээс үзэхэд ирэх жилд орлого өснө гэсэн хүлээлттэй хүмүүсийн нийт судалгаанд оролцогчдын дотор эзлэх хувь хэмжээ сүүлийн 3 жилд харьцангуй өндөр гарсан байна. Түүнчлэн сарын орлогод нэг их өөрчлөлт гарахгүй гэсэн болон буурна гэсэн үзэлтэй хүмүүсийн хувь хэмжээ жил ирэх тутам буурсан үзүүлэлттэй байна. Зөвхөн 2004 оны үр дүнг 2003 оныхтой харьцуулахад ирэх жилд сарын орлого нь өснө гэсэн хүлээлттэй хүмүүсийн хувь хэмжээ 25 хувиар нэмэгдсэн ба харин орлого огт өөрчлөгдөхгүй гэсэн хүмүүсийн хувь хэмжээ 9.3 хувиар буурсан ба мөн орлого буурна гэсэн үзэл бодолтой хүмүүсийн хувь хэмжээ ч зохих хувиар /6.0/ багассан байна. Өөрөөр хэлбэл ирэх жилд орлого өснө гэсэн үзэлтэй хүмүүсийн хэмжээ 2003 оныхоос 15.6 хувиар нэмэгдсэн байхад орлогод өөрчлөлт орохгүй байх гэсэн дундыг сахисан үзэл бодолтой хүмүүсийн тоо хэмжээ 22 хувиар багассан байна. Орлого буурах байх гэсэн гутранги үзэлтэй хүмүүсийн хувь хэмжээ өмнөх оныхоос хамгийн ихээр буюу 56.4 хувиар буурсан үзүүлэлт гарсан нь олон түмний хувьд эдийн засаг сэргэж ахуй амьдрал сайжирна гэсэн өөдрөг хүлээлт байгааг харуулж байна.

Орлогын өөрчлөлтийн талаарх хүлээлтийн харьцуулалт, 2003-2004

	2003		2004		Өөрчлөлт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Хувь	2004/2003
Маш ихээр өснө			32	5.1		
Бага зэрэг өснө	359	47.2	342	54.6	+ 7.4	+ 15.6 %
Өөрчлөгдөхгүй	321	42.2	206	32.9	- 9.3	- 22.0 %
Бага зэрэг буурна	80	10.6	28	4.6	- 6.0	- 56.4 %
Маш их буурна			20	2.8		
Дүн	760	100.0	628	100.0		

2003-2004 оны орлогын өөрчлөлтийн хүлээлтийг графикаас үзүүлбэл



Тав. Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ ханшны өөрчлөлт

Ард түмний өдөр тутмын хэрэглээ болсон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ ханш нь амьжиргааны төвшинд нөлөөлдөг нэг гол хүчин зүйл билээ. Иймээс төр засгаас эдгээр бараа бүтээгдэхүүний үнэ ханшийг барьж байх бодлого баримталдаг хэдий ч зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн дагуу байнга өөрчлөгдөн хэлбэлзэж байдаг. Манай орны хувьд хэрэглээний сагсанд орсон 206 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн дунджаар инфляцыг тооцдог. 2003 оны хувьд инфляцын төвшин 4.7 хувь байсан хэмээн статистикын үзүүлэлт байдаг хэдий ч энэ нь төдийлэн бодитой тоо байж чаддаггүй. Өөрөөр хэлбэл бараа бүтээгдэхүүний үнэ ханш энэ хэмжээнээс хамаагүй өндөр хувь хэмжээгээр нэмэгдсэн байдаг. Одоо судалгаанд оролцогчид энэ талаар ямар үзэлтэй байгааг авч үзье. Судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 90 хувь нь өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ ханш өнгөрсөн жилд өссөн гэж хариулсан байна. Харин буурсан гэсэн үзэлтэй хүмүүс судалгаанд оролцогчдын дөнгөж 2.8 хувийг эзэлж байхад үнэ ханш нэг их өөрчлөгдөөгүй гэсэн хүмүүс 6.8 хувь байна. Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ ханш өссөн гэсэн хүмүүсийн 32 хувь нь маш ихээр өссөн, 58.4 бага зэрэг өссөн гэж үзэцгээжээ.

Хэдийгээр засгийн газраас үнэ ханшийг тогтворжуулах, инфляцийг бууруулах арга хэмжээ авч байгаа ч гэсэн олон түмэн, хэрэглэгчдийн хувьд өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ ханш өсөн нэмэгдсээр байгааг энэхүү үзүүлэлт тод томруун харуулж байна. Энэхүү үзүүлэлтийг өмнөх онуудынхтай харьцуулж үзвэл 2000 онд судалгаанд оролцогчдын 80 хувь, 2001 онд 88.7 хувь, 2002 онд 78.6 хувь, 2003 онд 67.6 хувь нь тус тус өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өмнөх жилийнхээс өссөн гэж үзэж байсан бол энэ жил 90.4 хувь болж огцом нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл олон түмний үнэлэлт дүгнэлт, төр засгийн албан ёсны тоо баримт хоёрын хооронд маш их ялгаа зөрөө гарч байна гэсэн үг юм. Иймээс манай орны хувьд статистикийн албан ёсны тоо баримтуудыг гаргах аргачлал болон гаргаж буй механизм нь оновчтой бус байна гэж үзэж болохоор байна.

ӨХБ-ны үнийн өөрчлөлтийн харьцуулалт

	2003		2004		Өөрчлөлт	
	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	2004/2003
Өссөн	67.6	514	90.4	566	+ 22.8	+ 33.7 %
Өөрчлөгдөөгүй	30.0	228	6.8	43	- 23.2	- 77.3 %
Буурсан	2.4	18	2.8	19	+ 0.4	+ 16.6 %
Дүн	100.0	760	100.0	628		

Дээрх хүснэгтээс үзэхэд өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өссөн гэсэн хүмүүс 2003 оныхоос 33.7 хувиар нэмэгдсэн ба харин үнэ ханшид өөрчлөлт ороогүй гэсэн хүмүүсийн судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн дотор эзлэх хувь хэмжээ 2003 оныхоос 77.3 хувиар буурч өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ ханш хэрэглэгчдэд ашигтай нөлөө үзүүлж буурсан гэсэн хүмүүс өмнөх жилийнхээс 16.6 хувиар нэмэгдсэн байна. Нэг үгээр хэлэхэд судалгаанд оролцсон арван хүн тутмын ес нь өнгөрсөн жилд бараа бүтээгдэхүүний үнэ ханш өссөн гэсэн хариулт өгчээ.


Өнгөрсөн нэг жилийн хугацаанд гарсан өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ ханшны өөрчлөлтийн талаар хэрэглэгч олон ийм үзэл хандлагатай байгаа бол ирэх жилд үнэ ханш хэрхэн өөрчлөгдөнө гэж үзэж, таамаглаж байгааг авч үзье. Судалгаанд оролцогчдын өгсөн хариултаас үзэхэд тийм ч нааштай зэрэг үзүүлэлт гарахааргүй байна. Тухайлбал судалгаанд оролцсон нийт хүмүүсийн 81.7 хувь нь ирэх жилд өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ ханш цаашид ч өснө гэсэн хандлагатай байна. Харин дөнгөж 6 хувь нь л буурах байх гэсэн таамаглалтай байхад 12.3 хувийн хувьд өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ ханшид ирэх жилд нэг их өөрчлөлт орохгүй болов уу гэсэн бодолтой явдаг байна. Тэгвэл одоо өмнөх жилүүдийн судалгаанд оролцогчид ямар үнэлэлт, өгч байсныг нэгтгэн авч үзье.

ӨХБ-ны үнийн өөрчлөлтийн талаарх хүлээлтийн харьцуулалт, 2000-2004 / хүснэгтээр/

	2000		2001		2002		2003		2004	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Ихээр өснө	127	18.7	157	22.8	172	11.5			137	21.9
Бага өснө	323	47.6	418	60.8	842	56.1	504	66.3	375	59.8
Өөрчлөлтгүй	160	23.5	70	10.2	256	17.1	192	25.3	77	12.3
Бага буурна	53	7.8	32	4.6	212	14.1	64	8.4	7	1.2
Их буурна	16	2.4	10	1.5	18	1.2			32	4.8
Дүн	679	100.0	687	100.0	1500	100.0	760	100.0	628	100.0

Эндээс өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ ханш буурна гэсэн эерэг хүлээлт жил ирэх тутам багассаар байгаа нь тодорхой харагдаж байна. Тухайлбал 2002 онд судалгаанд оролцогчдын 14.1 хувь нь ийм хүлээлттэй байсан бол 2003 онд 8.4 хувь, 2004 онд 6.0 хувь болж тус тус буурчээ. Түүнчлэн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ ханш өснө гэсэн сөрөг хүлээлттэй хүмүүс 2002 онд судалгаанд хамрагдагсадын 67.6 хувийг эзэлж байсан бол 2003 онд 66.3 хувь, 2004 онд бүр өсч 90.7 хувь болсон байна.

ӨХБ-ны үнийн өөрчлөлтийн талаарх хүлээлтийн харьцуулалт, 2000-2004 / графикаар/



Зөвхөн сүүлийн нэг жил буюу 2003 ба 2004 оны судалгаануудын үр дүнгүүдийг харьцуулан үзэхэд өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ ханш өмнөх жилийнхээс өссөн гэсэн үзэлтэй хүмүүс 2004 онд 2003 оныхоос 14.1 хувиар өсөн буюу 20.8 хувь нэмэгдсэн байна. Бараа бүтээгдэхүүний үнэ ханш өмнөх жилийнхээс өөрчлөгдөөгүй гэсэн хүмүүсийн хувь хэмжээ өмнөх оныхоос 59.0 хувиар буурсан бол өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ ханш өмнөх оныхоос буурсан гэж үзсэн хүмүүсийн эзлэх хувь хэмжээ ихээхэн нэмэгдсэн буюу 2.5 дахин өссөн байна. Гэвч ингэж буурсан гэж үзсэн хүмүүсийн судалгаанд оролцогчдын нийт тоо хэмжээнд эзлэх хувь нь маш бага байгаа юм.


Орлогын өөрчлөлтийн талаарх хүлээлтийн харьцуулалт, 2003-2004

	2003		2004		Өөрчлөлт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Хувь	2004/2003
Өссөн	514	67.6	513	81.7	+ 14.1	+ 20.8 %
Өөрчлөгдөөгүй	228	30.0	77	12.3	- 17.7	- 59.0 %
Буурсан	18	2.4	38	6.0	+ 3.6	2.5 дахин
Дүн	760	100.0	628	100.0		

Зургаа. Ажил эрхлэлтийн талаарх олон түмний санал бодол

Ажилгүйдэл өнөөдөр манай орны хамгийн эмзэг асуудлын нэг болоод байгаа билээ. Жил бүр олон мянган залуучууд их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв төгсөж байгаа боловч тэдний маш цөөн хэсэг нь ажлын байраар хангагдаж байна. Гэвч хөдөлмөр эрхлэлтийн албанд эдгээр хүмүүсийн цөөн хувь нь л

бүртгүүлж байгаа бөгөөд иймээс ч албан ёсоор гаргасан статистикын тоо баримтад ажилгүйчүүдийн тоо хэмжээ 33.3 мянга гэж тоологдсон байна. Хэрэв үүнийг 2002 оны статистик үзүүлэлттэй харьцуулбал 8.0 хувь буюу 2.4 мянган хүнээр нэмэгдсэн дүн гарч байна.



Ажилгүйдлийг нэмэгдүүлж буй нэг гол хүчин зүйл нь хөдөөгөөс хот руу шилжиж буй их нүүдэл юм. Мал аж ахуйгаа алдсан олон зуун малчид, үр хүүхдээ дагасан олон зуун өрх, хот суурин, хөгжил соёл бараадсан олон мянган залуучууд гээд олон хүн төв суурин газар бараадан ирэх болсноор ажилгүйдлийн тоог улам бүр өсгөж байна. Ялангуяа тодорхой боловсрол, мэргэжилгүй хүмүүсийн хувьд ажил хөдөлмөр эрхлэх боломж ихээхэн хязгаарлагдмал байгаа нь нөгөө талаар ядуурлыг нэмэгдүүлж байна. Энэ бүхэн нь албан ёсны тоо баримтууд бөгөөд тэгвэл манай судалгаанд хамрагдсан хүмүүс ажилгүйдлийн талаар ямар санал бодолтой байгааг авч үзье.

Ажилгүйдлийн хэмжээ өмнөх жилийнхтэй харьцуулбал энэ жил яаж өөрчлөгдсөн бэ гэсэн эхний тандах асуултыг тавьсан бөгөөд судалгаанд оролцсон хүмүүсийн 57.7 хувь нь нэмэгдсэн гэж хариулсны 31.5 хувь нь маш ихээр нэмэгдсэн гэсэн байхад 26.2 хувь нь бага зэрэг л нэмэгдсэн гэж үзсэн байна. Харин 15.6 хувь нь ажилгүйдэл өмнөх жилийнхээсээ бага зэрэг буурсан гэж үзсэн бол 26.7 хувь нь ажилгүйдлийн хэмжээ өмнөх оныхоо төвшинд байгаа гэж хариулсан байна. Харин ажилгүйдэл их хэмжээгээр буюу илт багассан гэж өөдрөгөөр үнэлэх хүн судалгаанд оролцогчдын дундаас гарсангүй.

Ажилгүйдлийн өөрчлөлтийн харьцуулалт

	2003		2004		Өөрчлөлт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Хувь	2004/2003
Нэмэгдсэн	283	37.2	362	57.7	+ 20.5	+ 55.1 %
Өөрчлөгдөөгүй	274	36.0	167	26.7	- 9.3	- 25.8 %
Багассан	203	26.8	99	15.6	- 11.2	- 41.7 %
Дүн	760	100.0	628	100.0		

Хүснэгтээс үзэхэд ажилгүйдэл өмнөх оныхоос нэмэгдсэн гэсэн үзэлтэй хүмүүсийн хувь хэмжээ өмнөх оныхоос 55.1 хувиар өссөн байхад буурсан гэсэн хүмүүсийнх 41.7 хувиар багассан байна. Түүнчлэн ажилгүйдлийн хувьд өмнөх оныхоос нэг их өөрчлөгдөөгүй гэсэн үзэлтэй хүмүүсийн хувь хэмжээ ч 2004 онд 2003 оныхоос 25.8 хувиар багассан байна. Ажилгүйдэл 2004 онд 2003 оныхоос буюу судалгааны хоорондын жилийн хугацаанд нэмэгдсэн гэсэн ерөнхий дүгнэлт эндээс хийж болох бөгөөд шалтгаан нь өмнө нь бидний дурьдсан олон хүчин зүйлээс хамааралтай юм.

Дараах хүснэгтэд судалгаа хийж эхэлсэн 2000 оноос хойшхи ажилгүйдлийн талаар өгсөн үнэлэлтийг нэгтгэн харууллаа. Эндээс та бүхэн ажилгүйдлийн талаар судалгаанд оролцогчид ямар үнэлэлт дүгнэлттэй байсан талаар өөрсдөө шинжлэн анализ үзээрэй.


	2000		2001		2002		2003		2004	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Ихээр өссөн	9	1.3	3	0.4	14	0.9			197	31.5
Бага өссөн	90	13.2	40	5.8	348	23.2	283	37.2	165	26.2
Өөрчлөлтгүй	255	37.6	312	45.4	338	22.5	274	36.1	167	26.7
Бага буурсан	243	35.8	255	37.1	488	32.5	203	26.7	99	15.6
Их буурсан		12.1	77	11.3	312	20.9				0.0
Дүн	679	100.0	687	100.0	1500	100.0	760	100.0	628	100.0

Хэрэв бид энэ жилийн судалгааг анхын жилийн судалгаа буюу суурь оны судалгаатай харьцуулвал сонирхолтой үр дүн гарах нь тодорхой. Тухайлбал ажилгүйдэл маш ихээр нэмэгдсэн гэсэн үзүүлэлт анхны жилийнхээс 30.2 хувиар өссөн буюу 24.2 дахин нэмэгдсэн байх жишээтэй. Ажилгүйдэл бага зэрэг нэмэгдсэн гэж хариулсан хүмүүсийн хувь хэмжээ 12.9 хувь буюу 1.9 дахин нэмэгдсэн байхад ажилгүйдэл өмнөх жилийнхээс огт өөрчлөгдөөгүй гэсэн хүмүүс 10.9 хувиар буурч 2000 оныхоос 28.9 хувиар багассан байна. Харин ажилгүйдэл бага зэрэг буурсан гэсэн үзэлтэй хүмүүсийн нийт судалгаанд оролцогчдын дотор эзлэх хувь хэмжээ 20.2 хувиар багасч 56.4 хувиар буурсан байна. Энэхүү харьцуулалтыг та бүхэнд дараах хүснэгтэд тодорхой харууллаа.

Ажилгүйдлийн талаарх үнэлэлт / хүснэгтээр/

	2000		2004		Өөрчлөлт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Хувь	2004/2000
Маш ихээр өссөн	9	1.3	197	31.5	+ 30.2	+ 24.2 дахин
Бага зэрэг нэмэгдсэн	90	13.2	165	26.2	+ 12.9	+ 1.9 дахин
Өөрчлөгдөөгүй	255	37.6	167	26.7	- 10.9	- 28.9 %
Бага зэрэг буурсан	243	35.8	99	15.6	- 20.2	- 56.4 %
Маш их буурсан	82	12.1		0.0		
Дүн	679	100.0	628	100.0		

Ажилгүйдлийн талаарх үнэлэлт / графикаар үзүүлбэл/



Ажил эрхлэх боломж жилийн дараа гэхэд хэрхэн өөрчлөгдөнө гэж та үзэж байна вэ гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 13.5 хувь нь маш ихээр сайжирна гэсэн бол 28.3 хувь бага зэрэг сайжирна, 43.5 хувь энэ жилийнхээс нэг их өөрчлөгдөхгүй, 7.2 хувь бага зэрэг муудна, 7.5 хувь маш ихээр муудна гэсэн хариулт өгчээ. Ажил эрхлэх боломжийн талаар судалгаанд оролцогчид ямар хүлээлттэй байгааг 2003 ба 2004 оныг харьцуулан авч үзье.

	2003		2004		Өөрчлөлт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Хувь	2004/2003
Сайжирна	332	43.7	362	57.7	+ 14.0	+ 32.0 %
Өөрчлөгдөхгүй	328	43.1	167	26.7	- 16.4	- 38.1 %
Муудна	1000	13.2	99	15.6	+ 2.4	+ 18.2 %
Дүн	760	100.0	628	100.0		

Эндээс үзэхэд ажил эрхлэх боломж цаашид сайжирна гэсэн үзэлтэй хүмүүсийн хувь хэмжээ өмнөх оныхоосоо 32 хувиар өссөн байхад буурна буюу муудна гэсэн хүмүүсийн хувь хэмжээ мөн 18.2 хувиар өссөн байна. Гэвч эерэг хандлага нь илүү хувь хэмжээтэй байгаа нь нааштай үнэлгээ болж байна.


Долоо. Бизнесийн орчны талаарх үнэлэлт дүгнэлт

Өнгөрсөн жилийн хугацаанд засгийн газраас бизнесийн орчинг сайжруулах талаар олон арга хэмжээ авсан ба хамгийн гол нь аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын дээд хэмжээ 40 хувь байсныг 30 болгон бууруулсан билээ. Бизнес эрхлэхэд учирдаг элдэв саад бэрхшээл, хүнд суртлыг багасгах талаар ч олон талт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Өнөөдөр манай улсын хувьд ДНБ-ний 70 гаруй хувийг хувийн хэвшлийнхэн үйлдвэрлэж байгаа ба энэ хирээр бизнес дэх төрийн оролцоо багасч байна. Олон түмэн бизнесийн орчны талаар ямар үнэлэлт дүгнэлттэй явдгийг мэдэж түүнийг үйл ажиллагаандаа тусгаж байх нь аливаа сайн засаглал, төр засгийн нэг гол шинж нь болдог. Иймээс ч бидний явуулж буй „Хэрэглэгчдийн итгэлийн индекс,, энэхүү судалгаа нь төр захиргааны байгууллага болоод бодлого боловсруулагчдын хувьд анхааран судалж үзэх нэг үндсэн гарын авлага болох болов уу хэмээн итгэж байна.

Судалгаанд оролцсон хүмүүсийн 2.3 хувь нь өнгөрсөн жилд бизнесийн орчин илт сайжирч ахисан гэж үзсэн байхад 39.2 хувь нь бага зэрэг сайжирсан гэж үзжээ. Харин 22.8 хувь нь бизнесийн орчин өмнөх жилийнхээс огт өөрчлөгдөөгүй хэвэндээ байна гэсэн бол 16.1 хувь нь өмнөх оныхоос бага зэрэг муудсан, 19.6 хувь нь илт муудсан хэмээн үзэцгээсэн байна. Тэгвэл энэхүү үзүүлэлтийг өмнөх жилүүдийнхтэй харьцуулж үзье.


	2002		2003		2004		Өөрчлөлт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Хувь	2004/2002
Илт сайжирсан	104	6.9			14	2.3	- 4.6	- 33.3 %
Бага зэрэг сайжирсан	404	26.9	344	45.3	246	39.2	+ 12.3	+ 45.7 %
Өөрчлөгдөөгүй	372	24.8	318	41.8	143	22.8	- 2.0	- 8.1 %
Бага зэрэг муудсан	428	28.5	98	12.9	101	16.1	- 12.4	- 43.5 %
Маш их муудсан	192	12.8			124	19.6	+ 6.8	+ 53.1 %
Дүн	1500	100.0	760	100.0	628	100.0		

Судалгаанд оролцогчдын өгсөн хариултаас үзэхэд бизнесийн орчин өнгөрсөн нэг жилийн хугацаанд ихээхэн муудсан гэж үзэж болохоор байна.



Тухайлбал 2003 онд судалгаанд оролцогчдын 45.3 хувь нь бизнесийн орчин өмнөх оныхоос сайжирсан гэж үзэж байсан бол 2004 онд энэ хэмжээ 41.5 хувь болж 3.8 хувиар багассан ба бизнесийн орчин өмнөх жилийнхтэй харьцуулахад муудсан гэсэн хүмүүс 2003 онд судалгаанд хамрагдагсадын 12.9 хувийг эзэлж байсан бол 2004 онд энэ хэмжээ 35.7 хувь болж даруй 22.8 хувиар өссөн байна. Жилийн хугацаанд бизнесийн орчинд өөрчлөлт гараагүй гэсэн үзэлтэй хүмүүс 2003 онд судалгаанд оролцогчдын 41.8 хувийг эзэлж байсан бол 2004 онд 22.8 хувь болж 19 пунктээр багассан байна.

Бизнесийн орчны талаарх өөрчлөлтийн харьцуулалт



Одоо бизнесийн орчны өөрчлөлтийн талаар судалгаанд оролцогчид ямар хүлээлттэй байгаа авч үзье. Дараа жил гэхэд бизнесийн орчин илт сайжирна гэсэн хүмүүс санал асуулгад оролцогчдын 12.1 хувийг, бага зэрэг сайжирна гэсэн хүмүүс 40.9 хувийг, огт өөрчлөгдөхгүй гэсэн үзэлтэй хүмүүс 27.6 хувийг, бага зэрэг муудна гэсэн бодолтой хүмүүс 6.3 хувь, илт муудна гэсэн хүмүүс 13.1 хувийг тус тус эзэлж байна. Өмнөх жилийн буюу 2003 оны судалгаатай харьцуулбал бизнесийн орчин сайжирна гэж үзэгсэд 5 хувиар өссөн байхад муудна гэсэн үзэлтэй хүмүүсийн хувь 10-аар буурсан байна.

	2002		2003		2004		Өөрчлөлт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Хувь	2004/2002
Илт сайжирна	96	6.4			75	12.1	+ 5.7	+ 89.1 %
Бага зэрэг сайжирна	496	33.1	365	48.0	256	40.9	+ 7.8	+ 23.5 %
Өөрчлөгдөхгүй	466	31.1	272	35.8	173	27.6	- 3.5	- 11.2 %
Бага зэрэг муудна	276	18.4	123	16.2	39	6.3	- 12.1	- 65.7 %
Маш их муудна	166	11.0			85	13.1	+ 2.1	+ 19.1 %
Дүн	1500	100.0	760	100.0	628	100.0		

Найм. Ядуурал ба түүний төлөв байдал

Өнөөдөр дэлхий дахины хамгийн анхаарал татсан асуудлын нэг нь ядуурал болоод байгааг бид мэднэ. Даяаршлагдан интеграцчилагдаж байгаа өнөө үед улс орнуудын хоорондын харилцаа, хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлэхэд саад болж нэг хүчин зүйл нь ядуурал юм. Иймээс ч НҮБ-аас Мянганы хөгжлийн зорилтуудыг дэвшүүлэн тавьж түүний хүрээнд шийдвэрлэх хамгийн нэн тэргүүний асуудлыг ядуурлыг бууруулах хэмээн тунхагласан билээ.

Дэлхий нийтийн хөгжлөөс ихээхэн хоцорсон, алслагдмал байрлалтай манай орны хувьд ядуурал улам бүр өсөн нэмэгдсээр байна. Хэдийгээр албан ёсны статистик тоо баримтуудаас үзэхэд ядуурлын хэмжээ 30 гаруй хувьтай гэж гардаг ч гэсэн бодит байдалд манай орны нийт хүн амын 60 орчим хувь нь ядуу зүдүү амьдралтай байгаа юм. Ялангуяа сүүлийн жилүүдэд хөдөө орон нутагт ядуурал ихээр нэмэгдэж байна. Түүнчлэн хот, хөдөөгийн хоорондын ялгаа зөрөө, орлогын тэгш бус байдал зэрэг нь ядуурлыг нэмэгдүүлсээр байна. Засгийн газраас ядуурлыг бууруулах тал дээр олон арга хэмжээ авч байгаа ч төдийлэн үр дүн гарахгүй байна. Олон улсын байгууллага, хандивлагчдын зээл тусламжийг ч энэ чиглэлд хангалттай зарцуулж байгаа боловч үр дүн нь мөн л харагдахгүй байна.

Манай судалгааны хувьд өнгөрсөн нэг жилийн хугацаанд ядууралд ямар өөрчлөлт гарсныг гаргах зорилт тавьсан бөгөөд судалгааны дүнгээс үзэхэд өнгөрсөн жилийн хугацаанд ядуурал маш ихээр өссөн гэсэн хүмүүс судалгаанд оролцсон нийт хүмүүсийн 35 хувийг эзэлж байхад бага зэрэг нэмэгдсэн гэсэн хүмүүс 29.6 хувийг хамарч байна. Харин өнгөрсөн жилтэй харьцуулахад ядууралд нэг их өөрчлөлт гараагүй гэсэн үзэлтэй хүмүүс судалгаанд хамрагдагсадын 18.9 хувийг эзэлсэн бол ядуурал бага зэрэг буурсан гэсэн хүмүүс 15.8 хувийг эзэлж байна. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд ядуурал ихээр буурсан гэж үзэх хүн судалгаанд оролцогчдын дундаас нэг ч гарсангүй.


Эндээс үзэхэд судалгаанд оролцогчдын дийлэнх олонх буюу 64.6 хувь нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд манай улсын хувьд ядуурал нэмэгдсэн гэж үзсэн бол буурсан гэсэн нь дөнгөж 15.8 хувь байна. Өөрөөр хэлбэл манай улсын хувьд ядуурал буурах биш өсөх чиглэлтэй явж байгаад төр засгийн байгууллагууд, бодлого боловсруулагчид анхаарлаа хандуулж дорвитой арга хэмжээ авах цаг болжээ. Одоо өмнөх оны судалгааны дүнтэй энэ жилийнхийг харьцуулан авч үзье.

	2003		2004		Өөрчлөлт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Хувь	2004/2003
Ядуурал өссөн	422	55.5	405	64.6	+ 9.1	+ 16.3 %
Өөрчлөгдөөгүй	276	36.3	123	18.9	- 17.4	- 47.9 %
Бага зэрэг буурсан	62	8.2	100	15.8	+ 7.6	+ 92.6 %
Дүн	679	100.0	628	100.0		

Хүснэгтээс үзэхэд ядуурал өссөн гэсэн үзүүлэлт өнгөрсөн оныхоос 9.1 хувь буюу 16.3 хувиар нэмэгдсэн бол ядуурлын хэмжээнд өөрчлөлт гараагүй гэж үзсэн хүмүүсийн хувь хэмжээ өмнөх оныхоос даруй 47.9 хувиар буурсан байна. Харин өмнөх жилтэй харьцуулахад энэ онд ядууралд бага зэрэг бууралт гарсан гэсэн үзэлтэй хүмүүсийн хувь хэмжээ ихээхэн нэмэгдэж 92.6 хувиар өссөн байна.

Ядуурал нэмэгдсэн гэсэн үзүүлэлтүүдийг авч үзвэл анхны буюу 2000 оны судалгаанд оролцогчдын 60.9 хувь өссөн гэсэн үзэлтэй байсан бол 2001 онд 67.8 хувь болж өссөн ба 2002 онд 61.6 хувь, 2003 онд 55.5 хувь болж буурч байснаа 2004 онд эргээд 64.6 хувь болж өссөн байна. Өөрөөр хэлбэл сүүлийн 2 жилд ядуурал нэмэгдсээр ирлээ гэсэн үг. Харин ядуурал өмнөх оныхтой харьцуулбал буурсан гэсэн үзэлтэй хүмүүс 2000 оны судалгаанд оролцогчдын 15.2 хувийг эзэлж байсан бол 2001 онд 9.4 хувь болж буурснаа 2002 онд 14.4 хувь болж өсч 2003 онд ахин буурч 8.2 хувь болсон бол 2004 онд 15.8 хувь болж өслөө. Ийнхүү ядуурлын бууралтын талаар олон түмний ойлголт, үзэл жил жилд ихээхэн хэлбэлзэл, өөрчлөлттэй байгаа нь нарийн тодорхой тоо баримт байдаггүй, тэдэнд үнэн зөв ойлголт өгдөггүйтэй холбоотой байж болох юм.

Ядуурлын өөрчлөлтийн талаарх олон түмний санал бодол, 2000-2004



Одоо судалгаанд оролцогчид ядуурлын цаашдын хандлагын талаар ямар санал бодолтой байгааг үзэцгээе. Өөрөөр хэлбэл жилийн дараа гэхэд ядуурал хэрхэн өөрчлөгдөх талаар судалгаанд оролцогчид ямар хүлээлттэй байгааг авч үзье. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 20.1 хувь нь ирэх жилд ядуурал маш ихээр өснө гэсэн сөрөг хүлээлттэй байгаа бол маш ихээр буурна гэсэн бодолтой хүмүүс дөнгөж 3.5 хувь байна. 33.2 хувь нь ядуурал ирэх жилд бага зэрэг өсөх байх гэсэн хандлагатай байхад 16.6 хувь нь бага зэрэг буурах байх гэсэн хүлээлттэй байна. Харин судалгаанд оролцогчдын 26.6 хувь нь жилийн дараа гэхэд ядуурлын байдалд нэг их өөрчлөлт гарахгүй буюу хэвэндээ байна гэсэн үзэлтэй байна.


Нийт судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 53.3 хувийн хувьд ядуурал буурах биш нэмэгдэнэ гэсэн байгаа нь хамгийн анхаарал татсан зүйл бөгөөд нэг үгээр хэлэхэд олон түмний дунд ядуурал цаашид ч өсөн нэмэгдэнэ гэсэн хандлага зонхилж байгааг харуулж байна. Ер нь өнгөрсөн 5 судалгааны дүнгээс үзэхэд ядуурал цаашид ч өсч нэмэгдэнэ гэсэн үзэлтэй хүмүүсийн нийт судалгаанд оролцогчдын дунд эзлэх хувь хэмжээ 50 хувиас буурахгүй байгаа бөгөөд иймээс манай орны хамгийн хурц, тулгамдсан асуудал болох ядуурлыг бууруулах тал дээр Засгийн газраас эрчимтэй, оновчтой, олон түмэнд хүрсэн арга хэмжээ авах хэрэгтэй байгааг харуулж байна. Доорх хүснэгтэд 2000 оноос хойш ядуурлын цаашдын төлөв байдлын талаар судалгаанд оролцогчид ямар санал бодолтой байсныг үзүүлээ.

	2000		2001		2002		2003		2004	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Өснө	410	60.4	431	62.7	740	49.2	387	50.9	334	53.3
Өөрчлөлтгүй	164	24.2	162	23.6	358	23.9	271	35.7	167	26.6
Буурна	105	15.4	94	13.7	402	26.9	102	13.4	127	20.1
Дүн	679	100.0	687	100.0	1500	100.0	760	100.0	628	100.0

Ядуурлын хэмжээ өснө гэсэн хүлээлт сүүлийн 3 жил дараалан нэмэгдсэн байгаа нь хэдийгээр олон хүчин зүйлээс шалтгаалсан / тухайлбал сүүлийн хэдэн жилийн ган, зуд гэх мэт байгалийн гамшиг/ байж болох хэдий ч хамгийн гол нь засгийн газраас ядуурлыг бууруулах талаар авч явуулж буй бодлого, шийдвэр үр дүнгээ өгөхгүй байгаатай холбоотой нь тодорхой. Ядуурлын төлөв байдлын талаарх сүүлийн хоёр судалгааны үр дүнг харьцуулан үзье.

	2003		2004		Өөрчлөлт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Хувь	2004/2003
Ядуурал өснө	387	50.9	334	53.3	+ 2.4	+ 4.7 %
Өөрчлөгдөхгүй	271	35.7	167	26.6	- 9.1	- 25.4 %
Буурна	102	13.4	127	20.1	+ 6.7	+ 150.0 %
Дүн	679	100.0	628	100.0		

2004 онд ядуурал өснө гэсэн хүлээлттэй хүмүүсийн хувь хэмжээг 2003 оныхтой харьцуулахад 4.7 хувиар, тоон үзүүлэлтээр бол 2.4 хувар өссөн бол ядуурал бүүрна гэсэн нааштай хүлээлттэй хүмүүсийн хувь хэмжээ харьцангуй ихээр буюу 2003 оныхтой харьцуулахад 1.5 дахин нэмэгдсэн байгаа нь олон түмэн ядуурлыг бууруулах тал дээр төр засгаас дорвитой арга хэмжээ авах байх гэсэн найдлага, хүлээлттэй байгааг харуулж байна. Эцэст нь хэлэхэд ядуурлыг бууруулах тал дээр шийдвэртэй арга хэмжээ авахгүй бол энэ нь нийгэмд сөрөг үр дагавар авчрахуйц хэмжээнд тул очоод байна.



Ес. Ханшийн өөрчлөлтийн талаарх олон түмний санаа бодол

Улс орны эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлыг харуулдаг нэг гол үзүүлэлт нь валютын ханш байдаг. Манай орны мөнгөний бодлогыг хэрэгжүүлэгч Монгол Банкнаас мөнгөний хатуу бодлого явуулж төгрөгийн ханшийг унагаахгүй барьж байх бодлого баримталж байна. Гэсэн хэдий ч улс орны эдийн засгийн хөгжилтэй уялдаатайгаар төгрөгийн ханш унасаар байгаа бөгөөд өөрөөр хэлбэл америк доллартай харьцах төгрөгийн ханш жил ирэх тутам нэмэгдсээр байна. 2003 оны эцэст ам.доллар төгрөгийн ханш 1: 1168 байсан бол өнөөдөр 1:1170 болж өслөө. Төгрөгийн худалдан авах чадвар ингэж буурсаар байгаа нь олон хүчин зүйлээс хамааралтай хамааралтай нь тодорхой.

Он	2000	2001	2002	2003
Ханш /US\$1:₮	1097.0	1102.0	1125	1168


Судалгаанд оролцогчид төгрөгийн ханшны талаар ямар хүлээлттэй явдгийг авч үзвэл ам.доллартай харьцах төгрөгийн ханш ирэх жилд өснө буюу төгрөгийн худалдан авах чадвар буурна гэсэн үзэлтэй хүмүүс судалгаанд оролцогчдын 3.9 хувийг эзэлж байхад бага зэрэг өснө гэсэн хүмүүс 40.9 хувь, төгрөгийн ханш тогтвортой байна гэсэн бодолтой хүмүүс 35.5 хувь, төгрөгийн ханш буурна гэсэн буюу төгрөгийн худалдан авах чадвар бага зэрэг сайжирна гэсэн хүмүүс 8.4 хувь, их хэмжээгээр сайжирна гэж үзэгсэд 11.3 хувийг тус тус эзэлж байна. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 44.8 хувь нь ирэх жилд төгрөгийн ханш унана гэсэн бол 19.7 хувь нь өснө гэсэн өөдрөг хүлээлттэй байна.

2002 оны үзүүлэлттэй харьцуулахад төгрөгийн ханш маш ихээр өснө гэсэн хүмүүсийн хувь хэмжээ 2004 онд 39.1 хувиар багассан бол бага зэрэг өснө гэсэн хүмүүсийн хувь хэмжээ 2002 оныхоос 5.4 хувиар өссөн байна. Харин төгрөгийн ханш буурна гэж буюу төгрөгийн худалдан авах чадвар сайжирна гэсэн үзэлтэй хүмүүсийн хувь хэмжээ энэ онд ихээхэн нэмэгдсэн ба тухайлбал бага зэрэг буурна гэсэн хүмүүс 2002 оныхоос дөнгөж 1.2 хувиар нэмэгдсэн байхад маш ихээр буурна гэсэн хүмүүсийн хувь хэмжээ 2002 оныхоос 12.5 дахин өссөн байна. Гэвч төгрөгийн ханш буурна гэсэн үзэлтэй хүмүүсийн судалгаанд оролцогчдын дунд эзлэх хувь хэмжээ өөрөө харьцангуй бага /19.7 хувь/ байгаа юм.

	2002		2004		Өөрчлөлт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Хувь	2004/2002
Маш ихээр өснө	96	6.4	24	3.9	- 2.5	- 39.1 %
Бага зэрэг өснө	582	38.8	256	40.9	+ 2.1	+ 5.4 %
Өөрчлөгдөхгүй	684	45.6	222	35.5	- 10.1	- 22.1 %
Бага зэрэг буурна	124	8.3	52	8.4	+ 0.1	+ 1.2 %
Маш их буурна	14	0.9	74	11.3	+ 10.4	+ 12.5 дахин
Дүн	1500	100.0	628	100.0		

Хэдийгээр төр засгаас төгрөгийн ханшийг тогтворжуулах талаар арга хэмжээнүүд авч хэрэгжүүлсээр байгаа, санхүүгийн зах зээл харьцангуй хурдацтай өсөн нэмэгдэж байгаа, банкны салбар эрчимтэй хөгжиж байгаа хэдий ч төгрөгийн ханшны уналтыг тогтоох, чангаруулах талаар илүү хүч чармайлттай ажиллах хэрэгтэй байна.

Төгрөгийн ханшны өөрчлөлтийн талаарх харьцуулалт, 2002-2004



Арав. Цалин хөлсний өөрчлөлтийн талаарх үнэлэлт


Манай орны хүн амын, тэр дундаа төрийн болон хувийн хэвшилд ажиллаж буй хүмүүсийн орлогын гол эх үүсвэр нь цалин хөлс байдаг. Түүнчлэн 120 гаруй мянган тэтгэвэрийнхний амьжиргааны гол эх үүсвэр нь мөн л тэтгэвэр тэтгэмж байдаг. Өөрөөр хэлбэл хуримтлал хийх боломж бололцоо байхгүй байгаа өнөөгийн нөхцөлд хэрэглэгчдийн амьдрах гол эх сурвалж нь цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж болж байна. МАХН 2000 онд төрийн эрхийг авахдаа цалин, тэтгэвэрийн хэмжээг 2-3 дахин нэмэгдүүлнэ гэж амласан ба цалин тэтгэвэрийг хэд хэдэн удаа тодорхой хувь хэмжээгээр нэмсэн хэдий ч энэ амлалт одоо хир бүрэн биелэгдэж чадаагүй гэж олон түмэн үзэж шүүмжилж байгаа юм. Гэвч Засгийн газар энэхүү амлалтаа бүрэн биелүүлсэн гэж үздэг бөгөөд тэгвэл одоо судалгаанд оролцогчид энэ талаар ямар үнэлэлт дүгнэлттэй байгааг авч үзье.

Таны цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж өнгөрсөн жилийн хугацаанд яаж өөрчлөгдсөн бэ? гэсэн асуултад маш ихээр өссөн гэж хариулах хүн судалгаанд оролцогчдоос гарсангүй. Харин бага зэрэг л нэмэгдсэн гэж 39.2 хувь нь хариулсан бол 33.2 хувь нь огт өөрчлөгдөөгүй буюу нэмэгдээ ч үгүй, буураа ч үгүй гэсэн хариулт өгчээ. Судалгаанд оролцсон нийт хүмүүсийн 15.6 хувь нь нэмэгдэх нь байтугай харин ч бага зэрэг буурсан гэсэн бол 12 хувь нь бүр ихээр буурсан гэсэн байна. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчдын 27.6 хувийн хувьд цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж нь өнгөрсөн оныхтой харьцуулахад буурсан байна. Тэгвэл энэхүү үзлэлтийг өмнөх жилүүдийнхтэй харьцуулж үзье.

	2002		2003		2004		Өөрчлөлт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Хувь	2004/2003
Цалин хөлс өссөн	894	59.5	296	38.9	246	39.2	+ 0.3	+ 0.7 %
Огт өөрчлөгдөөгүй	476	31.7	429	56.5	208	33.2	- 23.3	- 41.2 %
Харин ч буурсан	130	8.8	35	4.6	174	27.6	+ 23.0	+ 6 дахин
Дүн	1500	100.0	760	100.0	628	100.0		

Дээрх хүснэгтээс үзэхэд өнгөрсөн жилийн хугацаанд цалин хөлс нэмэгдсэн гэж үзсэн хүмүүсийн хувь хэмжээ дөнгөж 0.3 хувь буюу 2003 оныхтой харьцуулахад 0.7 хувиар өссөн байхад харин буурсан гэсэн хүмүүсийн хувь хэмжээ 23 хувиар буюу 2003 оныхоос 6 дахин нэмэгдсэн байна. Түүнчлэн өөрчлөлт гараагүй гэж үзсэн хүмүүсийн хувь хэмжээ ч өнгөрсөн жилийнхээс 41.2 хувиар буурчээ.

Цалин хөлс, тэтгэвэрийн өөрчлөлтийн талаарх үнэлгээ, 2002-2004



Одоо цалин, тэтгэвэр жилийн дараа гэхэд хэрхэн өөрчлөгдөнө гэж судалгаанд оролцогсод таамаглаж байгааг авч үзэцгээе. Судалгаанд оролцогчдын 47.1 хувь нь ирэх жилийн хугацаанд тэдний цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж тодорхой хэмжээгээр өснө гэсэн эерэг хүлээлттэй байгаа бол 10.4 хувь нь буурах байх гэсэн гутранги таамаглалтай байна. Харин 42.5 хувь нь жилийн хугацаанд цалин тэтгэвэрт онцын өөрчлөлт гарахгүй хэвэндээ л байна гэсэн үзэлтэй байна. Цалин хөлс өснө гэсэн эерэг үзэлтэй хүмүүсийн хувьд 7.2 хувь нь маш ихээр өснө гэсэн бол 39.9 хувь нь бага зэрэг л өснө гэсэн хүлээлттэй байна. Цалин хөлс ирэх жил өсөх биш харин ч буурна гэсэн хүмүүсийн 5.8 хувь нь бага зэрэг буурна гэсэн бол 4.6 хувь нь их хэмжээгээр буурч магадгүй гэсэн таамаглалтай байна.


	2003		2004		Өөрчлөлт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Хувь	2004/2003
Цалин хөлс өснө	240	31.6	334	47.1	+ 15.5	+ 49.0 %
Өөрчлөгдөхгүй	480	63.2	167	42.5	- 20.7	- 32.7 %
Буурна	40	5.2	127	10.4	+ 2 дахин	+ 200.0 %
Дүн	679	100.0	628	100.0		

Эндээс үзэхэд ирэх жилд цалин хөлс өснө гэсэн хүмүүс 2003 оныхтой харьцуулахад 49 хувиар нэмэгдсэн байхад буурна гэсэн хүмүүсийн хувь хэмжээ 2 дахин нэмэгджээ. Хэрэглэгч олон түмний хувьд энэ онд өмнөх оныхоос гутранги үзэл хандлагатай болсон нь Засгийн газраас цалин хөлсний талаар авч хэрэгжүүлж буй бодлого шийдвэрт итгэх итгэл суларч байна уу гэсэн таамаглал төрүүлж байна. Гэвч энд анхаарах нэг гол зүйл бол ирэх онд цалин тэтгэвэр буурах байх гэсэн хүмүүсийн судалгаанд оролцогчдын дунд эзлэх хувь хэмжээ харьцангуй бага / 10.4 хувь/ байгаа явдал юм. Одоо 2000 оныг суурь он болгон цалин хөлсний өөрчлөлтийн талаарх хүлээлтийг харьцуулан гаргаж үзье.

	2000	2001	2002	2003	2004
Цалин хөлс өснө	100.0	45.4	137.9	66.5	99.1
Огт өөрчлөгдөхгүй	100.0	121.8	63.6	131.6	88.5
Харин ч буурна	100.0	360.4	88.3	123.2	260.0

Дээрх хүснэгтээс харахад цалин хөлс нэмэгдэнэ гэсэн хүмүүсийн хувь хэмжээ сүүлийн 2 жил дараалан өсч байгаа боловч суурь он болох 2000 оны төвшнөөс буурсан дүн ажиглагдаж байна. Гэтэл цалин хөлс буурна гэсэн хүлээлттэй хүмүүсийн хувь хэмжээ сүүлийн 3 жил дараалан өссөөр иржээ. Цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийн хувьд нэг их өөрчлөлт гарахгүй хэвэндээ байна гэсэн хүмүүс судалгаанд оролцогчдын ихээхэн хувийг эзэлж байгаа нь жил бүрийн судалгаанаас тодорхой харагдаж байна. Энэ нь хэрэглэгч олон түмэн цалин хөлсний хувь нэмэгдэх эсвэл буурах талаар таамаглал дэвшүүлж чадахгүй байгаа явдал биш бөгөөд харин энэ нь бодлого боловсруулагчид болон түүнийг хэрэгжүүлэгчдийн зүгээс ямар шийдвэр, арга хэмжээ авах буюу авч болохыг таамаглах аргагүй буюу таамаглах боломжгүй байгаатай холбоотой юм. Өөрөөр хэлбэл иргэдийн хувьд амьжиргааных нь гол эх сурвалж болсон цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийн талаар төр засгаас авч хэрэгжүүлж байгаа болон авч хэрэгжүүлэх бодлого шийдвэрийг урьдчилан таамаглах бололцоогүй, тэдний үзүүлэх үр дагаварыг төсөөлөх аргагүй байгаагийн илрэл юм.

Цалин тэтгэвэрийн талаарх хүлээлтийн харьцуулалт, 2000-2004



Цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийн хувьд нэг их өөрчлөлт гарахгүй хэвэндээ байна гэсэн хүмүүс судалгаанд оролцогчдын ихээхэн хувийг эзэлж байгаа нь жил бүрийн судалгаанаас тодорхой харагдаж байна. Энэ нь хэрэглэгч олон түмэн цалин хөлсний хувь нэмэгдэх эсвэл буурах талаар таамаглал дэвшүүлж чадахгүй байгаа явдал биш бөгөөд харин энэ нь бодлого боловсруулагчид болон түүнийг хэрэгжүүлэгчдийн зүгээс ямар шийдвэр, арга хэмжээ авах буюу авч болохыг таамаглах аргагүй буюу таамаглах боломжгүй байгаатай холбоотой юм. Өөрөөр хэлбэл иргэдийн хувьд амьжиргааных нь гол эх сурвалж болсон цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийн талаар төр засгаас авч хэрэгжүүлж байгаа болон авч хэрэгжүүлэх бодлого шийдвэрийг урьдчилан таамаглах бололцоогүй, тэдний үзүүлэх үр дагаварыг төсөөлөх аргагүй байгаагийн илрэл юм. Манай Засгийн газар, яам, агентлагуудын хувьд тогтвортой, тодорхой үе шат бүхий бодлого шийдвэр, үйл ажиллагаа явуулдаггүйгээс ард олонд чухам ямар шийдвэр, арга хэмжээ авахыг урьдчилан таамаглах боломж олддоггүй билээ. Иймээс энэ асуудалд анхаарлаа хандуулж тогтвортой, таамаглаж болохуйц үйл ажиллагаа явуулдаг болох шаардлагатай байна.

Арван нэг. Хөрөнгө оруулалтын орчны талаар

Монгол улс зах зээлийн эдийн засгийн нийгэмд шилжээд арав гаруй жил өнгөрч байна. Нийгмийн нэг системээс нөгөөд шилжих шилжилтийн үйл явц үндсэндээ дуусч эдийн засгаа тогтвортой өсгөх шаардлага зүй ёсоор тулгарч байна. Монгол улсын засгийн газраас улс орны хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг зарлаж тэдгээрт хийх хөрөнгө оруулалтыг түлхүү дэмжих бодлого баримталж байгаа билээ. Манай улс нь олон улсын ангиллын хувьд нэн ядуу орны тоонд орох бөгөөд гадны зээл тусламжгүйгээр өөрөө бие даан хөгжих, эдийн засгаа сэргээх чадваргүй билээ. Иймээс ч гадаадын хөрөнгө оруулалтыг татах талаар ихээхэн чармайлт гаргаж байна. Ер нь өнөөдөр аливаа улс орон гадаадын хөрөнгө оруулалтыг татах талаар өрсөлдөж байна гэж хэлж болно. Өндөр өрсөлдөөнт энэхүү орчинд оновчтой, ухаалаг бодлого шийдвэр гаргаж байж амжилт олох нь тодорхой. Энэхүү судалгаагаар бид хэрэглэгчид чухам ямар салбарт хөрөнгө оруулалт хийхийг илүүтэйд үзэж буй гаргах зорилгоор Хэрэв та хөрөнгө оруулалт хийх бол ямар салбарыг сонгох вэ? гэсэн асуулт тавьсан юм. Өөрөөр хэлбэл эдийн засгийг хөгжүүлж улс орныхоо хоцрогдлыг багасгахын тулд чухам ямар салбарыг түлхүү анхаарах хэрэгтэй гэж олон түмэн үзэж буйг гаргахыг зорьсон болно. Судалгаанаас үзэхэд хэрэглэгчид олон салбар,

чиглэлийг сонгосон бөгөөд хамгийн олон хувийн дэмжлэг авсан нь аялал жуулчлалын салбар байна. Судалгаанд оролцогчдын 19.3 хувь нь аялал жуулчлалыг сонгосон бол 14.2 хувь нь уул уурхай, 13.5 хувь нь барилга угсралт, 9.8 хувь нь боловсролыг, эрүүл мэнд, дэд бүтцэд тус бүр нь 9.5 хувь, 8.4 хувь нь хөдөө аж ахуйг, 7.2 нь хүнд аж үйлдвэрийг, 5.3 хувь нь хүнсний үйлдвэрийг, 2.8 хувь нь оёдол нэхмэлийн салбарыг тус тус сонгосон байна. Тэгвэл энэ үзүүлэлтийг өмнөх онуудынхтай харьцуулж үзье.

Хөрөнгө оруулалтыг түлхүү оруулах салбаруудын талаарх санал

		2002	2003	2004
1	Хүнд аж үйлдвэр	2.3	2.6	7.2
2	Соёл, урлаг	3.1	3.2	0.0
3	Хүнсний үйлдвэр	14.3	10.5	5.3
4	Хөдөө аж ахуй	9.6	4.8	8.4
5	Боловсрол	14.1	17.7	9.8
6	Оёдол, нэхмэл	3.1	0.9	2.8
7	Барилга угсралт	7.6	10.5	13.5
8	Эрүүл мэнд	9.6	14.4	9.5
9	Уул уурхай	7.9	7.8	14.2
10	Дэд бүтэц	13.5	13.4	9.5
11	Аялал жуулчлал	14.6	13.8	19.3

2003 онд боловсролын салбарт хөрөнгө оруулалт хийхийг судалгаанд оролцогчид илүүтэйд үзэж байсан бол 2004 онд аялал жуулчлалын салбарыг илүүтэйд үзсэн байна. Түүнчлэн уул уурхай, барилга угсралт, боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц зэрэг өнөөдөр эрчимтэй өсөн хөгжиж байгаа салбаруудад хөрөнгө оруулалт хийх нь ашигтай хэмээн судалгаанд оролцогчид үзэцгээсэн байна. Өөрөөр хэлбэл бид энэхүү хариултаас өнөөдөр манай улсад эдийн засгийн ямар салбарууд хамгийн эрчимтэй хөгжиж буйг харж болохоор байна.

Дараах графикаас харахад жил ирэх тутам хувь хэмжээ нь нэмэгдсээр ирсэн салбар бол барилга угсралтын салбар байна. Сүүлийн жилүүдэд манай орны хувьд хамгийн эрчимтэй хөгжиж буй салбар нь барилгын салбар гэдэг нь тодорхой бөгөөд энэ ч утгаар судалгаанд оролцогчид тус салбарыг сонгосон байна. Эрүүл мэндийн салбарын хувьд 2003 онд ихээхэн өндөр хувь хэмжээ эзэлж байсан бол 2004 онд буурч гарааныхаа төвшинд хүрч очсон нь харагдаж байна. Үүнтэй адил дүр зураг боловсролын салбарт харагдаж байна. 2003 онд хамгийн өндөр хувь хэмжээтэй байсан тус салбар энэ онд нилээд хойгуур орсон байна. Жил ирэх тутам хувь хэмжээ нь буурсаар байгаа ганц салбар бол хүнсний үйлдвэр бөгөөд өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчдын хувьд энэ салбарт хөрөнгө оруулалт хийх сонирхол улам бүр буурсаар байна.

Хөрөнгө оруулалт түлхүү шаардлагатай салбарын талаарх санал



Хэдийгээр бага хувь хэмжээтэй байгаа ч гэсэн хүнд үйлдвэрийн салбар судалгаанд оролцогчдын сонирхлыг татсаар байгаа нь түүний хувь хэмжээ жил ирэх тутам нэмэгдсээр байгаагаас харж болно. Манай орны эдийн засгийн амин сүнс болсон хөдөө аж ахуйд хөрөнгө хийх сонирхол харьцангуй бага байгааг сүүлийн хэдэн жил дараалан болсон зуд, ган зэрэг байгалийн гамшигтай холбон авч үзэж болох юм. Ноос ноолуур, арьс шир зэрэг мал аж ахуйн түүхий эдийн ихэнх нь гадагш урсан гарч газар тариалангийн үйлдвэрлэл байгалиас хараат байгаа нь иймэрхүү шийдвэр гагахад хүргэсэн болов уу.

Арван хоёр. Эдийн засгийн хоцрогдлыг даван туулах талаарх судалгаанд оролцогчдын санал, бодол

Монгол улс нэн ядуу улс орны зэрэглэлд хамрагддаг ба нэг хүнд ногдох Дотоодын Нийт Бүтээгдэхүүний хэмжээ 490 ам.доллар байгаа нь дэлхийн хамгийн ядуу буурай орнуудын төвшинд байна гэсэн үг юм. Эдийн засгийн хөгжлийн хувьд 20 гаруй жилээр ухраад байна. Иймээс улс орноо хөгжүүлж эдийн засгаа сэргээн хоцрогдлоо даван туулах нь Монгол улсын хувьд нэн тэргүүний зорилт болоод байгаа нь тодорхой. Энэхүү хоцрогдлоос хэзээ гарч дэлхий нийтийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах вэ гэдэг талаар судалгаанд оролцогчид ямар санал бодолтой явдгийг сонирхох үүднээс энэхүү асуултыг тавьсан юм. Түүнчлэн хэрэглэгчдийн санал бодолд ямар өөрчлөлт гарч буйг харьцуулан харуулахыг зорьсон болно.


Хариултаас үзэхэд судалгаанд оролцогчдын 2.6 хувь нь ойрын 3 жилд багтан энэхүү хоцрогдлоос гарчих болов уу гэсэн өөдрөг үзэлтэй байгаа бол 15.9 хувийн хувьд энэ хугацаа 5 жилээс наашгүй байна. Харин 19.1 хувь нь 7-10 жилийн дараа л эдийн засгаа хоцрогдлоо даван гарч чадна хэмээн үзэцгээсэн бол 57.5 хувь нь үүнд 10 жилээс багагүй хугацаа шаардлагатай гэсэн байна. Судалгаанд оролцогчдын 4.9 хувь нь Монгол улс эдийн засгийн хоцрогдлоос хэзээ ч гарч чадахгүй гэсэн үзэлтэй байна.

	2003		2004		Өөрчлөлт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Хувь	2004/2003
Ойрын 3 жилд	35	4.6	16	2.6	- 2.0	- 43.4 %
Ойрын 5 жилд	342	45.0	99	15.9	- 29.1	- 64.6 %
7-10 жилийн дараа	116	15.3	119	19.1	+ 3.8	+ 24.8 %
10 жилээс хойш	267	35.1	361	57.5	+ 22.4	+ 63.8 %
Хэзээ ч чадахгүй			33	4.9		
Дүн	760	100.0	628	100.0		

Ойрын 3 жилд эдийн засгаа сэргээн хоцрогдлоос гарч чадна гэж үзсэн хүмүүс өмнөх судалгаанд 4.6 хувийг эзэлж байсан бол энэ онд 2.6 болж 2 хувиар буюу 2003 оныхтой харьцуулбал 43.4 хувиар буурсан байна. Түүнчлэн ойрын 5 жилд багтан эдийн засгийн хоцрогдлоос гарч чадна гэсэн итгэлтэй хүмүүсийн хувь хэмжээ багасч 64.6 хувиар буурсан байна. Өөрөө хэлбэл ойрын 5 жилд Монгол улс эдийн засгаа сэргээж дэлхийн улс орнуудтай хөл нийлүүлэн алхаж чадна гэж үзэх хүмүүсийн хувь хэмжээ жил ирэх тутам буурч байна. Энэ нь нэг талаас олон түмний эдийн засгийн талаарх ойлголт, мэдлэг сайжирч асуудлыг бодитойгоор харах чадвар нэмэгдсэнийг харуулж байгаагаас гадна нөгөө талаар түргэн хурдацтайгаар хөгжиж хоцрогдлоос богино хугацаанд гарч чадна гэсэн итгэл найдвар буурч байгааг тодорхой үзүүлж байна.

Эдийн засгийн хоцрогдлыг даван туулахад 7-10 жил болон түүнээс ч урт хугацаа хэрэгтэй гэж үзэж буй хүмүүс судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 57.5 хувийг эзэлж байгаа юм. Ялангуяа 10 жилээс хойш эдийн засгийн хоцрогдлыг даван туулж чадна гэсэн бодолтой хүмүүс 2003 оныхоос 63.8 хувиар нэмэгдсэн байна. Харин Монгол улс энэхүү хоцрогдлоосоо хэзээ ч гарч чадахгүй гэсэн гутранги үзэлтэй хүмүүс судалгаанд оролцогчдын 4.9 хувийг эзэлж байгаа нь 2002 оныхоос 2.7 хувиар бага байгаа юм. Ийнхүү Монгол улс эдийн засгийн хоцрогдлоо арилгаж даван туулахад ихээхэн хугацаа хэрэгтэй хэмээн судалгаанд оролцогчдын дийлэнх үзсэн байна.

Эдийн засгийн хоцрогдлыг даван туулахад шаардагдах хугацаа, 2002-2004




Арван гурав. „Амьдрах боломж,-ийн талаарх үнэлгээ

Аливаа төр засгийн үндсэн үүрэг бол ард түмэндээ ажиллаж амьдрах таатай нөхцөл бололцоог бүрдүүлж өгөх явдал байдаг. Энэ үүргээ хир зэрэг биелүүлснээр нь тухайн төрийг үнэлдэг. Хөгжиж буй болон ядуу буурай орнуудын хувьд амьдрах нөхцөл боломж муу байдгаас гадаад улс орон руу очиж ажиллах, цагаачлах явдал өргөн дэлгэрсэн байдаг бөгөөд үүнийг манай орны жишээ тодорхой харуулж байна. Өнөөдөр монголын 120 гаруй мянган иргэн гадаадад ажиллаж амьдарч байгаагийн ихэнх нь илээр болон хараар ажил хөдөлмөр эрхэлж байгаа юм. Тэд дуртайдаа бус, амьдралын нөхцөл байдлаа сайжруулах гэж, ахиухан мөнгө хөрөнгө олох гэж, хөгжилтэй орны таатай орчин нөхцөлд ажиллах гэж явж буй нь тодорхой. Нэг үгээр хэлбэл Монголын төр өнөөдөр ард түмэндээ амьдарч ажиллах бололцоо нөхцлийг тэр бүр хангаж өгч чадахгүй байна гэсэн үг. Энэ нь нэг талаас манай орны нийгэм эдийн засгийн байдал, хөгжлийн төвшинтэй холбоотой хэдий ч нөгөө талаас төр засгаас авч хэрэгжүүлж буй бодлого шийдвэр төдийлэн оновчтой, үр өгөөжтэй болж чадахгүй байгааг харуулж байна гэж үзэж болох юм. Иймээс Монголын төр ард түмнээ ажиллаж амьдрах нөхцөл боломжоор хир зэрэг хангаж байна гэж олон түмэн үздэгийг гаргах зорилгоор судалгаанд оролцогчдод энэхүү асуултыг тавьсан юм.

Судалгааны дүнгээс үзэхэд 6.1 хувь нь өнөөдөр Монгол оронд ажиллаж амьдрах нөхцөл боломж нэн таатай буюу маш өндөр байна гэсэн хариулт өгсөн бол 44.2 хувь нь амьдарч болж л байна гэжээ. Өөрөөр хэлбэл өнөө маргаашаа өнгөрөөгөөд болж л байна гэсэн байна. Тэгвэл 44.8 хувь нь манай улсад ажиллаж амьдрах нөхцөл бололцоо маш хүнд байна гэсэн бол 4.9 хувь нь тэсэхийн арга алга гэж буюу Монголын өнөөгийн эдийн засаг, улс төр, нийгмийн байдал нь олон түмэнд ажиллаж амьдрах боломжийг ханган өгч чадахгүй байна, цаашид энэ байдлаар үргэлжилбэл тэсэхийн арга алга гэсэн хариулт өгчээ. Судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 50.3 хувь нь амьдрах боломжийн хувьд эерэг буюу нааштай үнэлгээ өгсөн бол 49.7 хувь нь Монгол улсад амьдрах боломж муу байна гэсэн гутранги үнэлгээтэй байна. Тэгвэл одоо энэ үзүүлэлтийг өмнөх онуудынхтай харьцуулж үзье.

	2002		2003		2004		Өөрчлөлт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Хувь	2004/2003
Амьдрах боломж гайгүй байна	810	54.0	220	28.9	315	50.3	+ 21.4	+ 170 %
Амьдрах боломж муу байна	690	46.0	540	71.1	313	49.7	- 21.4	- 30.1 %
Дүн	1500	100.0	760	100.0	628	100.0		

Хүснэгтээс үзэхэд өнгөрсөн оныхтой харьцуулахад амьдрах боломж гайгүй байна гэсэн хариулт өгсөн хүмүүсийн нийт судалгаанд оролцогчдын дотор эзлэх хувь хэмжээ 21.4 хувиар нэмэгдсэн бол амьдрах боломж муу байна гэсэн хүмүүсийнх мөн 21.4 хувиар буурсан байна. Өөрөөр хэлбэл сүүлийн нэг жилийн хугацаанд төр засгаас ард түмнийхээ ажиллаж амьдрах орчныг сайжруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь олон түмэнд тодорхой хэмжээгээр хүрч тэр хирээр амьдрах боломж дээшилж байна гэсэн дүгнэлтийг эндээс хийж болох юм. Гэвч энэ бол зөвхөн өнгөрсөн нэг жилийн үр дүн бөгөөд ард түмний ажиллаж амьдрах таатай нөхцөл бололцоог бүрдүүлэх талаар цаашид хийх зүйл их байгаа гэдэг нь тодорхой. МҮХАҮТ-аас Монголын эдийн засаг, бизнесийн орчны судалгаа, Бизнесийн итгэлийн индекс зэрэг судалгаануудыг явуулж байгаа бөгөөд энэ бүгд нь Монгол улсад бизнес эрхлэх, ажиллаж амьдрах таатай бололцоо нөхцөл ямар байгааг бодитойгоор гаргаж олон нийт, холбогдох байгууллагад уламжлах, тэдний үйл ажиллагаанд тодорхой тусалцаа дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн болно.



Дээрх графикт сүүлийн гурван жилийн судалгаанд оролцогчид Монгол дахь амьдрах боломжийн талаар ямар санал, үнэлэлттэй байсныг тоймлон харуулсан бөгөөд „Амьдрах боломж,, цаашид улам сайжран дээшилнэ гэдэгт итгэлтэй байна.

Санал дүгнэлт

„Хэрэглэгчдийн итгэлийн индекс,, судалгааны 2004 оны үр дүн ийм байна. Бид энэ судалгааг явуулахдаа төр засгийн үйл ажиллагаа, бодлого шийдвэрийг шүүмжлэх гэж бус, харин тэдний хэрэгжүүлж буй эдийн засаг, нийгмийн шинжтэй арга хэмжээнүүд нь хэрэглэгч олон түмэнд яаж тусч нөлөөлж байгааг бодитойгоор гаргаж ирэхийг зорьсон болно. Тус судалгааны үр дүнг бодлого боловсруулагчид болон хэрэгжүүлэгчид анхааралдаа авч үйл ажиллагаа, шийдвэртээ бага боловч ашиглах буюу тусгаж байвал бидний зорилго биелэгдэх болно. „Хэрэглэгчдийн итгэлийн индекс,, энэхүү судалгааны үр дүнтэй холбоотойгоор гарах дүгнэлт гэвэл:

- Өнгөрсөн нэг жилийн хугацаанд төр засгаас авч хэрэгжүүлсэн эдийн засаг, нийгмийн шинжтэй бодлого, шийдвэр, арга хэмжээнүүд нь тодорхой

хэмжээгээр үр ашгаа өгч олон түмэнд хүрч байна. Үүнийг сарын орлого, инфляци, бизнесийн боломжийн талаар судалгаанд оролцогчдын өгсөн хариултуудаас харж болохоор байна.

- Харин ажилгүйдэл, ядуурлын асуудал өнгөрсөн жилийнхээс буураагүйгээр барахгүй нэмэгдэх шинжтэй болж байгаад судалгаанд оролцогчид сэтгэл зовж байгаа нь ажиглагдлаа. Өөрөөр хэлбэл Засгийн газраас эдгээр чиглэлүүдээр түлхүү анхаарч шийдвэртэй, үр дүнтэй арга хэмжээнүүд авахыг шаардаж байна.
- Судалгаанд хамрагдагсад, олон түмний ирээдүйдээ итгэх итгэл, төр засгийн бодлого шийдвэр тогтвортой байхад эргэлзэх эргэлзээ, итгэл найдвар тийм ч сайнгүй байна. Иймээс энэ чиглэлд ихээхэн анхаарч ажиллах шаардлагатай байна.
- Засгийн газраас авч хявуулж буй аливаа бодлого шийдвэрийг олон түмэнд сурталчлах, тайлбарлан таниулах тал дээр санаачлагатай ажиллах хэрэгтэй нь судалгааны явцад харагдаж байна. Өөрөөр хэлбэл ард олон төр засгийн бодлого, үйл ажиллаганы талаар ойлголт муутай явдаг нь асуудалд буруу хандах нөхцлийг бүрдүүлж өгч байна.

Эдийн засаг, бизнесийн орчныг сайжруулах, бизнес эрхлэх бололцоо нөхцлийг нэмэгдүүлэх чиглэлээр өнгөрсөн жилд Засгийн газраас олон чухал арга хэмжээ авсан билээ. Тухайлбал аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын дээд шатлал 40 байсныг 30 болгон бууруулсан ба газар хувьчлалын ажлыг эхлүүллээ. Бизнес, иргэдэд учирч буй захиргааны элдэв дарамт шахалт, хүнд суртлыг багасгах үүднээс „Нэг цэгийн үйлчилгээ,-г төрийн үйлчилгээний байгууллагуудад ажиллуулж эхэллээ.

Ийнхүү эдийн засаг, бизнесийн орчныг сайжруулах, ард түмний ахуй амьдралыг дээшлүүлэх талаар нааштай олон арга хэмжээ авч байгаа хэдий ч цаашид улам боловсронгуй болгох, илүү таатай бололцоо нөхцөл бүрдүүлэх, бий болгох шаардлага зүй ёсоор тулгарч байна. Энэ чиглэлээр хувийн хэвшлийг төлөөлөгч гол байгууллага болох МҮХАҮТ цаашид ч ихээхэн санаачлага, идэвхитэй ажиллах болно.